



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2020. 12. 07 № 29

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар шинэ коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед хүндэрч байгаа эдийн засгаа дэмжих зорилгоор 5.1 их наяд төгрөгийн санхүүжилттэй хөтөлбөр хэрэгжүүлэхээр зарласан. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д заасан “Цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх” тухай заалтын хэрэгжилттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасныг үндэслэн Танд асуулга тавьж байна. Үүнд:

1. Монгол улсад 2018 оны байдлаар бүртгэлтэй 170,166 аж ахуй нэгж бий. Үүнээс 85,749 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 68 хувь буюу 58,602 нь жижиг, дунд үйлдвэрийн салбарт хамаарч, нийт 1,256,356 ажиллах хүчний 77 хувь буюу 963,146 мянган хүн ажиллаж байна. Засгийн газрын хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад хамгийн их ажлын байрыг бий болгож, эдийн засгийг нуруундаа үүрч явдаг жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж, хичнээн ажлын байрыг хадгалж чадсан бэ?
2. 2020 оны төсвийг тодотгох асуудлыг хөндөн тавихад “Төсвөө тодотгож, хөрөнгө оруулалтын зардлаа тана гэж байгаа нь 1,500 аж ахуйн нэгж, 150,000 ажлын байраа хаа гэж байгаатай адил сонсогдож байна” гэж Сангийн сайд хариулж байсан. Тэгвэл үсчин, машин засвар, машин угаалга, томоохон зах болон үйлчилгээний төвүүдэд гар дээрээс худалдаа хийдэг иргэд, оёдолчид гэх зэрэг өдрийн орлогоороо өрхийн амьдралаа, өнөө маргаашийн хоолоо залгуулж буй 180 мянган иргэдээ дэмжихэд хэдэн төгрөг зарцуулсан бэ?
3. Монгол улсад нийт 897,427 өрх байна. Үүнээс хүүхэдтэй 531,000, хүүхэдгүй 366,427 өрх байдаг. Хүүхэдгүй өрхүүд цар тахлаас сэргийлэх Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хөтөлбөрт хэрхэн хамрагдсан талаар тодорхой мэдээлэл

2020000089



4. Монгол Улс зээлийн хүүгийн түвшнээр дэлхийд дээрээсээ 10 дугаар байрт жагсдаг. Арилжааны банкны зээлийн дундаж хүү 17%, хадгаламж зээлийн хоршооны зээлийн дундаж хүү 34.8%, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн дундаж хүү 37.2%, ломбардны зээлийн дундаж хүү 42% байна. 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаас 23 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Ерөнхий сайд ч хэвлэлийн хурал дээр Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга нартай тохиролцсон учраас 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл иргэдийн бүх зээл хойшлогдсон талаар мэдээлэл хийсэн. Гэвч Монголбанкны удирдлага, арилжааны банкууд, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагууд энэ шийдвэрийг янз бүрээр тайлбарлан хэрэгжүүлж байна. Засгийн газрын хуралдааны шийдвэр хүчин төгөлдөр байгаа эсэх талаар мэдээлэл өгнө үү?
5. Монгол улсын Ерөнхийлөгчийн төрөөс өрх бүрд нэг сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх санаачилгыг Засгийн газар дэмжээгүй. Ерөнхий сайд “Бүх зүйлийг Засгийн газар нь шийдэж чадахгүй. Тийм боломж бидэнд байхгүй” гэж тайлбарласан. Хэдхэн сарын өмнө Улсын Их Хурлын сонгуулийн өмнө нэг кг ямааны ноолуурт 20 мянган төгрөгөөр тооцож 178 тэрбум төгрөгийг бэлнээр тараасан Засгийн газар нийтээр хөл хорио тогтоосон эдгээр өдрүүдэд иргэддээ 180 тэрбум олгох боломжгүй гэсэн шалтгаанаа тайлбарлана уу.
6. Монгол Улсын төсвийн орлогын тал хувьд хүрэхүйц буюу 1.7 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний татвар төлөгчдийн асар их хэмжээний хөрөнгө зарцуулсан хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнгийн талаарх тодорхой тайлан гаргаж ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б. ПҮРЭВДОРЖ

2020000089